



## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Г Хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.3 дахь заалт, Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.14 дэх заалт, Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журмын 4.2. дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 4.5 дугаар зүйлийн 1.16 дахь заалт, 5.2 дугаар зүйлийн 1 дэх заалт, Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Хуульчдын холбооны Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын нэг багц цагийн сургалтын төлбөрийн хэмжээг 65,000 /жарантаван мянган/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн “Хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2014 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



П.ОДГЭРЭЛ